

**«Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт»  
(1920 – 1932) архивын баримт бичгийн эмхтгэлийн тухай**

*О.Батсайхан\**

Ардчилал шинэчлэлийн үрээр ОХУ – аас урьд хаалттай байсан архивын фондуудыг, ялангуяа БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны маш нууцын онцгой зэрэглэл бүхий тэмдэгтэй «тусгай хавтаст» баримтуудыг нээлттэй болгосны ачаар түүхийн үнэн бодит мэдээлэл, сурвалж агуулсан баримт бичгүүдийг судлаачид судлан илрүүлж, улмаар өргөн олон түмний хүртээл болгох сайхан боломж нээгдсэн билээ. 1992 онд байгуулагдсан Архивын салбарт хамтран ажиллах Монгол – Оросын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын ажлын хүрээнд доктор С.Дамдинсүрэн, доктор Шепелев В.Н. нарын хоёр улсын судлаачид сүүлийн жилүүдэд Оросын төрийн нийгэм улс төрийн түүхийн архив (РГАСПИ – Российский государственный архив социально-политической истории) – ын фондуудад хайлт судалгаа хийж, ОК(б)Н, БХК(б)Н-аас Монголын талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагаанд холбогдох 1920 – 1952 оны үеийн олон мянган хуудас баримт бичгийг олж ирүүлсэн юм. Үүний үр дүнд «Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт» гэсэн архивын эх сурвалж баримт бичгийн эмхтгэлийн 1 дүгээр ботийг (1920-1932) 2002 онд, 2 дугаар ботийг (1933-1952) 2003 онд тус тус хэвлэн нийтлэх, дараагийн он жилүүдийн өөрөөр хэлбэл 1953-1991 оны баримт бичгүүдийг нээлттэй болгохын хэрээр судлаж илрүүлж үргэлжлүүлэн боть болгож дэс дараатайгаар хэвлүүлэхээр төлөвлөсөн болно.

Энэ 2002 онд хэвлэгдэн гарч буй дээрх баримт бичгийн эмхтгэлийн нэгдүгээр боть болбоос Монголын түүхийн нэгэн онцлог үе болох 1920 онд Монгол Ардын Намын төлөөлөгчид ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн Товчоотой холбоо тогтоосон үеэс 1932 онд БХК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны Монголын комиссыг байгуулж Монголд явуулах бодлогыг үндсээр нь өөрчилж «Шинэ эргэлтийн бодлого» хэмээхийг хэрэгжүүлж эхэлсэн үеийг хамарч байна.

Энэхүү эмхтгэлд ОК(б)Н - БХК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, Зохион байгуулах Товчоо, Нарийн бичгийн дарга нарын газар зэрэг дээд удирдлагын түвшинд болон ОК(б)Н-ын

\*О.Батсайхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор(Sc.D), профессор

Сибирийн Товчоо, Алс Дорнодын Товчоо зэрэг бүс нутгийн байгууллагуудын хүрээнд Монголын талаар гаргаж байсан тогтоол, шийдвэр, протокол, тэмдэглэл, удирдамж, зөвлөмжүүд, ЗСБНХУ-ын Ардын комиссариатын Зөвлөлийн зарим чухал шийдвэр, хоёр орны удирдагчид, төлөөлөгчдийн янз бүрийн түвшний уулзалт ярианы тэмдэглэл, харилцсан захидал, бичиг цахилгаанууд зэрэг урьд өмнө нийтлэгдээгүй үлэмж хэмжээний чухал баримт, эх сурвалжууд орсон байна. Эмхтгэлийн хэвлэгдэн буй нэгдүгээр ботид нийт 191 баримтыг сонгон оруулсаны дөч шахам хувь нь ОК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны «тусгай хавтаст» багтсан шийдвэрүүд байна.

ОК(б)Н-БХК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, Зохион байгуулах Товчоо, Нарийн бичгийн дарга нарын газрын хуралдаанаас ЗХУ болон Монгол улсын цэрэг, улс төр, эдийн засаг, гадаад харилцааны төдийгүй Монголд ажиллуулах боловсон хүчний асуудал, Монголын удирдлагын бүрэлдхүүн, үйл ажиллагааны тухай асуудлыг ч авч хэлэлцэж, тодорхой шийдвэр гарган хэрэгжүүлж байсаныг эмхтгэлд орсон баримтуудаас харж болно.

Монголын талаар Коминтерний бодлогыг боловсруулах, Монгол дахь Коминтерний төлөөлөгчдийн ажиллагааг чиглүүлэн үнэлэлт дүгнэлт өгч, залж, жолоодож байсан тухай ЗСБНХУ-ын дээд удирдагчдын шийдвэрүүд эл эмхтгэлд тодорхой байр эзэлж байна. Эмхтгэлд Коминтерн болон ГХАК-ын шугамаар Монголд ажиллах чухал боловчон хүчнийг ОК(б)Н-ын Төв Хорооны Зохион байгуулах Товчоо, Нарийн бичгийн дарга нарын газар, Улс Төрийн Товчоогоор хэрхэн шалгаруулан томилж ажлын удирдамжийг хянан боловсруулж байсан тухай баримт бичгүүд, мөн Улс Төрийн Товчоо Коминтерний Гүйцэтгэх Хороогоор зуучлуулалгүй Монголын амьдралын чухал асуудлуудыг шууд шийдвэрлэж байсаныг харуулсан эх сурвалж бичгүүд орсон байна.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, үндэсний ардчилсан хувьсгал, Монгол улсын дотоодын хийгээд олон улсын амьдралд тулгарч байсан чухал зангилаа асуудлуудын талаарх Зөвлөлтийн нам, төрийн дээд удирдлагын байр суурь, бодлогыг тусгасан баримт бичгүүдийг багтаасан нь эл эмхтгэлийн бас нэгэн онцлог болжээ.

Монголчуудын үндэсний нэгдлийн тухай түүхэн ёсоор дэвшигдэж, Монгол үндэстний хуваагдмал байдлыг гэтлэн давах гэсэн зүй ёсны сонирхлыг илэрхийлсэн үзэл санааг бусад улс үндэстний эсрэг хандсан харгис үзэл мэтээр зэмлэн буруутгах, түүнд панмонголизм гэсэн нэр зүүж, үзэл суртал, улс төрийн хэт туйлширсан утга өгч хэрхэн гажуудуулах болсоныг харуулсан эх сурвалж бичгүүд цөөнгүй орсон нь баримт бичгийн эмхтгэлийн үнэ цэнийг улам өргөж байна.

Тус архивын баримт бичгийн эмхтгэлд томоохон байр эзэлж байгаа нэг гол чиглэл бол Монгол улсын эдийн засгийн амьдралыг төлөвшүүлэх, түүний дотор Монгол улсын банк санхүүгийн системийг шинээр үүсгэн байгуулахад онцгой анхаарал тавьж байсан тухай ба Зөвлөлт Монголын худалдаа эдийн засгийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр БХК(б)Н-ын Төв Хорооны болон ЗСБНХУ-ын АКнЗ-ийн гаргаж байсан тогтоол шийдвэрүүд юм.

Цэрэг, батлан хамгаалах асуудал, эрүүл мэнд, боловсрол, соёл шинжлэх ухааны асуудлаар БХК(б)Н-ын Төв Хороо, удирдах төв байгууллагууд их анхаарал тавьж, тогтоол шийдвэр гаргаж байсан тухай баримтууд тусдаа бие даасан эмхтгэл болгохоор бэлтгэж байгаа тул энэ талын баримт бичгүүдийг оруулаагүй болно.

БХК(б)Н Монголын талаарх бүх талыг хамарсан бодлого хэрэгжүүлэхдээ Монголд ажиллах ЗСБНХУ-ын бүрэн эрхт төлөөлөгч, КИГХ-ны төлөөлөгч, худалдааны төлөөлөгч, Монгол банкны ерөнхий хорооны дарга, төрөл бүрийн комисс, экспедицид ажиллаж байсан хүмүүсийн бүрэлдхүүнийг хэрхэн хянан баталж байсан тухай тэдгээрийн ажлын удирдамж, заавар, тайлан зэрэг баримтууд мөн Монголын өөрийнх нь боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарал тавьж байсныг харуулсан баримт бичгүүд эмхтгэлд тодорхой байр эзэлсэн байна.

Энэхүү эмхтгэлд орж буй баримт бичгүүд бүхэлдээ БХК(б)Н, Зөвлөлт төрөөс Монголын талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа, хоёр улсын хооронд тогтсон онцгой хэв маягийн харилцааны тухай урьд далд хаалттай байсан арвин баялаг мэдээллийн санг нээн өгч судлаач, сэхээтэн, оюутан, уншигч, өргөн олон түмний хүртээл болгож, хоёр улсын харилцааны түүхэн үнэнийг сэргээх, бидний танин мэдэхүйг уламжлал болсон өрөөсгөл ойлголт, элдэв гажуудлаас чөлөөлөх төдийгүй Монгол, Оросын найрсаг харилцаа, хоёр ард түмний өнөөгийн зорьж буй ардчилал, зах зээл, хүмүүнлэгийн харилцааны хөгжилд сургамж болох утгаараа үнэлж баршгүй ач холбогдолтой болжээ.

Энэ ботид Зөвлөлт Орос улсаас Монголын талаар хийгээд Дорнодахинд явуулж байсан бодлого, Монгол Зөвлөлт Оросын хооронд тогтсон өвөрмөц харилцааны зарим асуудлуудыг тусгасан олон тооны баримт бичгүүд анх удаа орж байна.

Энэ ботид хамаарсан баримт бичгүүдийг судлаач түүх сонирхогч хэн бүхэнд үзэж танилцах боломж нээснээрээ юуны өмнө 1920 иод оны үеийн Зөвлөлт Орос улсаас Ази дахин, улмаар дэлхий дахинд явуулж байсаны бодлогыг улам тодруулах боломж өгөхийн зэрэгцээ Монгол улсын түүх бодит байдлаар бичигдэх нөхцөл бүрдэх юм.